



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 5/27.

Ховд

Захирамж хүчингүй болгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.12 дахь хэсэгт заасны дагуу Сургуулийн захирлыг ажлаас чөлөөлөхдөө аймгийн Боловсролын газрын дүгнэлтийг үндэслээгүй, Боловсролын газрын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлөх үүргээ хэрэгжүүлээгүй тул Алтай сумын Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн Б/25 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

2. Т.Цэцэгбадамыг өмнө нь ажиллаж байсан Алтай сумын сургуулийн захирлын ажилд нь томилон ажиллуулахыг Засаг дарга /Х.Түмэндэлгэр/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийг Т.Цэцэгбадамд хүргүүлж, биелэлтийг хангах арга хэмжээ авч ажиллахыг Алтай сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Баатарсүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ДЭЛГЭРСАЙХАН